



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН
ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2026 он

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ДҮН
(2025 он)**

2026.01.30

Улаанбаатар хот

Үзүүлэлт		Хэрэгжилтийн хувь	Жин
1	2	3	4
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	"Алсын хараа – 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүн	86.8%	0.3
	Монгол Улсын Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт	86.6% ¹	
	Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөрийн хэрэгжилт	97.5%	
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн дүн (үнэлгээ)	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	96.3%	0.4
	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	96.04%	
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Хүний нөөцийн үйл ажиллагаан дахь чадахуйн зарчмын хэрэгжилт	ТАЗ	0.2
	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	98.0%	
	Ёс зүй, сахилга, хариуцлагын үнэлгээ	ТАЗ	
	Санхүүгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт	ҮАГ	
	Хяналт-шинжилгээний зөвлөмжийн хэрэгжилт	ЗГХХГ	
Хөндлөнгийн болон оролцогч талуудын үнэлгээ	Төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгааны дүн	ЗГХХГ	0.1
	Байгууллагын шударга байдлын үнэлгээ	АТГ	
	Нийтийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээ (ил тод байдал, шилэн дансны үнэлгээ)	ХЗДХЯ	
	Хэрэглэгчийн үнэлгээний дүн	86.1% ²	
Нэмэлт оноо	Байгууллагын үйл ажиллагааны ерөнхий дүнгийн өөрчлөлт (+ оноо)		
Ерөнхий үнэлгээ:		92.5%	1.0

¹ Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл, төлөвлөгөө, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгийн үзүүлэлтийн дундаж хувиар тооцсон болно.

² Байгууллагын хүрээнд цахимаар зохион байгуулсан үнэлгээний дүнг оруулсан.

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ҮР ДҮН

1. “АЛСЫН ХАРАА – 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ



“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэгт шууд хамаарах Засаглалын бодлогын хүрээний 2 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 2 арга хэмжээний хэрэгжилтийг тайланд тусгасан болно. Эдгээр зорилт, арга хэмжээний 2025 оны хэрэгжилтийг хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр тайлагнаж байгаа бөгөөд дүнг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.5-д

заасан арга зүй, аргачлалын дагуу хяналт-шинжилгээ хийхэд “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан холбогдох зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцын дундаж дүн – **86.8 хувь буюу “Үр дүнтэй”** гэж дүгнэгдсэн.

“2025 оны дэлгэрэнгүй тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А-1/1931 дүгээр албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд баталгаажуулсан болно”

2. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ



Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор “Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”-ийн 1.3.2.7. Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлж, төрийн болон орон нутгийн өмчит компани

болон компанийн нэгдэл хэлбэрээр ажилладаг төрийн өмчит компанийн үйл ажиллагааг уялдуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, шаардлагатай зарим компанийг олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний 1.1.2.1. Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд үе шаттай, нээлттэй худалдах арга хэмжээг хэрэгжүүлэх, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт”-ийн 1.1.2. Зах зээл дэх төрийн оролцоог бууруулна гэж тус тус батлагдсан.

“Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”-д 1 зорилт, 1 арга хэмжээ (1.3.2.7.), “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-д 1 зорилт, 1 арга хэмжээ (1.1.2.1.), “Монгол Улсын хөгжлийн 2025 оны

төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт"-ийн хөтөлбөрийн үр дүнд 1 үр дүн (1.1.2) тус тус тусгагдсан.

Нэг. "Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл":

д/д	Тэргүүлэх чиглэл	Зорилго	Зорилт
Нэг. Эдийн засгийн бодлого			
1.	1.3. Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулна.	1.3.2. Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд;	1.3.2.7. Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлж, төрийн болон орон нутгийн өмчит компани болон компанийн нэгдэл хэлбэрээр ажилладаг төрийн өмчит компанийн үйл ажиллагааг уялдуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, шаардлагатай зарим компанийг олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ.

1. "Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл" – **90.0 хувь буюу "Үр дүнтэй"** дүгнэгдсэн.

Хоёр. "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө":

д/д	ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт		Санхүүжилт	
						Суурь түвшин /2023 он/	Зорилготой түвшин /2025 он/	сая. төг	Эх үүсвэрийн ангилал
Нэг. Эдийн засгийн бодлого									
1.	1.1. Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	1.1.2. Зах зээл дэх төрийн оролцоог бууруулна.	1.1.2.1. Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд үе шаттай, нээлттэй худалдах арга хэмжээг хэрэгжүүлэх	Олон нийтийн хяналтад оруулах төрийн өмчит компани	тоо	2	5	100.0	Улсын төсөв

2. "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө" – **70 хувиар дүгнэгдсэн.**

Гурав. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт”:

д/д	Зорилтот үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин
Хөтөлбөрийн үр дүн							
1.1.2	Зах зээл дэх төрийн оролцоог бууруулна.	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгийн өгөөж /ROA/ <u>хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь</u>	хувь	2023	3.5	<u>77.7</u> (4.0)	9.64

3. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт” – **100.0 хувь буюу “Үр дүнтэй”**. **Тайлбар:** Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 67 хуулийн этгээдийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн аудитаар баталгаажсан тайлангийн дүнгээр тооцоход хөрөнгийн өгөөж 9.64 хувь байна. (2025 оны ROA нь 2026 онд гарна.)

/2025 оны дэлгэрэнгүй тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А-1/2515 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг зэрхлэх газарт хүрүүлж, хувийг Эдийн засаг, хөгжлийн яам болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт тус тус хүрүүлсэн бөгөөд Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлийг баталгаажуулсан болно/

3. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ



Монгол Улсын Их хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин”-г баталж, Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт” тус тус батлагдсан.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (ЗГҮАХХАХТ¹)-нд тусгагдсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хариуцан хэрэгжүүлэх **2 бодлогын 2 тэргүүлэх зорилтын 5 арга хэмжээг** хяналтад авч, хэрэгжилтийн тайланд явцын хяналт-шинжилгээ хийв.

¹ Төвчилсон үсгийн тайлал: ЗГҮАХХАХТ – Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Эдийн засгийн бодлого 3.1.2.4.485, Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого 4.1.4.2.1063, 4.1.4.2.1064, 4.1.4.2.1065, 4.1.4.2.1066 дугаар арга хэмжээнүүд, 2 дугаар хавсралтаар батлагдсан ЗГҮАХХАХТ-ний үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд төсвийн ерөнхийлөгчийн захирагчийн үр дүн – 1 (3.1.2.4, 4.1.4.2), хөтөлбөрийн үр дүн – 3 (3.1.2.4, 4.1.4.2, 4.1.4.2) нийт 4 үр дүн тусгагдсан байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 2 бодлогын 2 зорилтын 4 арга хэмжээний хэрэгжилтийн явцын зорилтот түвшин дунджаар – **97.5% буюу “Үр дүнтэй”**, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшингийн биелэлтийн дундаж **100.0% буюу “Үр дүнтэй”**-гаар тус тус дүгнэгдэж байна.

/2025 оны дэлгэрэнгүй тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А-1/2515 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, хувийг Эдийн засаг, хөгжлийн яам болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт тус тус хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд Төсвийн ерөнхийлөн захирагч оруулж баталгаажуулах тул эрх нээгдээгүй болно/

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ДҮН

1. БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Байгууллагын стратеги төлөвлөгөө”-тэй уялдуулсан 14 зорилт, 80 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **14 зорилтын дундаж 97.1 хувь, түүнийг хэрэгжүүлэх 80 арга хэмжээний дундаж 96.3 хувьтай** байна.

Эдгээр зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зохион байгуулалтын бүтцээр 55 орон тоотой байхаас Засгийн газрын 2025 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар орон тооны дээд хязгаарыг 51 болгон өөрчлөлт оруулж, 4 орон тоог цомхотгосон.

2025 онд үндсэн үйл ажиллагааны буюу урсгал зардалд 3,536,745.9 мянган төгрөг батлагдаж тайлант хугацаанд нэг удаа улсын төсвийн тодотгол хийгдэж, төсөв 688,000.0 мянган төгрөгөөр буурч 2,848,141.7 мянган төгрөг болж, 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 88.1 хувь буюу 2,509,262.3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй, 11.9 хувийн хэмнэлттэй ажилласан байна.

Хууль эрх зүйн хүрээнд:



Төрийн болон орон нутгийн өмчийн тухай (Нийтийн өмчийн хууль болон нэр өөрчлөгдөж) хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалыг сайжруулахад чиглэсэн анхдагч хуулийн (Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай анхдагч хууль нэртэйгээр) төслийг

боловсруулж, Засгийн газраас УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, улмаар Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар тус тус хэлэлцэн дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн Байнгын хороонд шилжүүлсэн.



Хууль, хяналтын байгууллагад хянагдаж байгаа захиргааны 11, иргэний 16, эрүүгийн 13, шүүхийн шийдвэр гүйцэтгүүлэх ажиллагаа хийгдэж байгаа 3, эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа хийгдэж байгаа 1, нийт 44 хэрэгт итгэмжлэлээр оролцож, тайлант хугацаанд захиргааны 4, иргэний 8, эрүүгийн 3, эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа хийгдсэн 1, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж дууссан 1, нийт 17 хэрэг эцэслэн ТӨБЗГ-ын талд шийдвэрлэгдсэнээр төрд учрах байсан 2,224,567.9 мянган төгрөгийн эрсдэлээс хамгаалсан байна.

Төрийн өмчит хуулийн этгээдэд олон улсын нийтлэг шаардлагад нийцсэн засаглалын зарчмыг нэвтрүүлэн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хяналтыг сайжруулах хүрээнд:

"Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл, танилцуулгыг Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар хуралдаанаар хэлэлцээд Засгийн газрын гишүүдийн саналыг тусган, "Шинэ итгэл-Эрс шинэтгэл" "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д нийцүүлэн дахин боловсруулахаар 30.4 дүгээр тэмдэглэлд тусган шийдвэрлэсэн. "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийг дахин боловсруулж, 18 хуулийн этгээдэд IPO хийх, 8 этгээдийн төрийн мэдлийн хувьцааг худалдах, 7 хуулийн этгээдэд бүтцийн өөрчлөлт хийх саналыг Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газраас УИХ-д уг үндсэн чиглэлийг батлах тогтоолын төслийг өргөн барихаар тогтсон.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг харгалзан төрийн өмчит компаниудад бүтцийн өөрчлөлт хийх, өөрчлөн зохион байгуулах, чиг үүргийн давхардлыг арилгах, үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах асуудлыг судалж, салбарын яамтай хамтран дараах компани, үйлдвэрийн газруудыг нэгтгэх, татан буулгах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Үүнд:

- "Баруун бүсийн эрчим хүчний систем" ТӨХК, "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийг "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-д нэгтгэх;
- "Богдын голын усан цахилгаан станц" ХХК, "Тосонцэнгэлийн усан цахилгаан станц" ХХК, "Тайшир-Гуулингийн усан цахилгаан станц" ХХК-ийг нэгтгэх.;
- Алтай-Улиастай Завхан салбар болон бусад түгээх сүлжээний салбаруудыг нийлүүлж, "Алтай-Улиастайн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК болгох;

- "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ-ыг "Эрчис Ойл" ХХК-д нэгтгэх;
- "Монгол-Кувейтын байгаль хамгаалах төв" ТӨААТҮГ-ыг "Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв" ТӨААТҮГ-т нэгтгэн зохион байгуулах;
- "Монголын үнэт цаасны клирингийн төв" ХХК-ийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-д нэгтгэн зохион байгуулах;
- "Аялал жуулчлалын хөгжлийн төв" ТӨААТҮГ-ыг татан буулгах.

Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, олон улсын туршлагыг судлах, үр ашгийг нэмэгдүүлэх, өмчлөлийн бодлогыг оновчтой болгох асуудлаар Эдийн Засгийн Хөгжлийн Хамтын Ажиллагааны Байгууллага /OECD/, Дэлхийн банк, Олон Улсын Валютын Сан, Азийн Хөгжлийн Банк, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк зэрэг олон улсын хөгжлийн байгууллагатай уулзалт хийх, хамтарсан семинар зохион байгуулах, олон улсын хурал, семинарт оролцох чиглэлээр 11 удаагийн арга хэмжээг тайлант онд авч хэрэгжүүлэн ажилласан.

2025 оны байдлаар уул уурхай, эрчим хүч, дэд бүтэц, зам, тээвэр, банк, санхүү, мэдээлэл харилцаа зэрэг салбаруудад толгой компани 84, тэдгээрийн охин, хараат компани 17 нийт 101 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газрууд үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдгээр компани, үйлдвэрийн газруудаас 100% төрийн өмчийн 73, төрийн өмчийн оролцоотой 22, олон нийтийн нээлттэй хувьцаат компани 6 байна. Хариуцлагын хэлбэрээр нь задалбал төрийн өмчит үйлдвэрийн газар (ТӨҮГ) – 15, төрийн өмчит хувьцаат компани (ТӨХК) – 28, төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани (ТӨХХК) – 30, төрийн өмчийн оролцоотой хаалттай хувьцаат компани (ХК) – 2, төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) – 19, төрийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн нийгэмлэг (ХНН) – 1, төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компани (ХК) – 2 байна.

Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр нь авч үзвэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (түүний харьяанд "Эрдэнэс Монгол" ХХК, "Эрчист Монгол" ХХК болон тэдгээрийн харьяа компаниудыг оролцуулаад нийт 41 ТӨК), Эрчим хүчний яам (түүний харьяанд 28 ТӨК), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (түүний харьяанд 14 ТӨК), Сангийн яам (түүний харьяанд 5 ТӨК), Зам, тээврийн яам (түүний харьяанд 5 ТӨК), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (түүний харьяанд 4 ТӨК), Эдийн засаг, хөгжлийн яам (түүний харьяанд 2 ТӨК), Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам (түүний харьяанд 1 ТӨК), Хууль зүй, дотоод хэргийн яам (түүний харьяанд 1 ТӨК) зэрэг нийт 11 хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын харьяа нийт 12 төрийн өмчит үйлдвэрийн газрын **"2026 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө"**-ний төслийг хэлэлцэн, санал дүгнэлт гарган Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулан, батлуулав. Эдгээр 12 төрийн өмчит үйлдвэрийн газар нь 2026 онд нийт 2030 ажиллагсадтайгаар 141,6 тэрбум төгрөгийн орлого олж, 140,6 тэрбум төгрөгийн зардал гарган 1,5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөгдөө.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох төрийн өмчийн ногдол ашгийн хувь, хэмжээг тогтоож, улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Улсын төсөвт 101,600.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэх ажлын хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 312 дугаар тогтоолоор Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2025 оны Улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг тогтоосон бөгөөд нийт 31 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн цэвэр ашгийн дүнгээс улсын төсөвт 78,208,9 сая төгрөг төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн.

2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 19 төрийн өмчит хуулийн этгээд 57,377,4 сая төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлж, биелэлт 73,4 хувьтай байна.

Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар харьяа 22 төрийн өмчит үйлдвэрийн газар, компаниудын 1,648 ш тендер бүхий нийт 641.6 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим системээр хянан, баталгаажуулсан. Үүнээс 153.0 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалтын, 484.1 тэрбум төгрөг нь урсгал зардал, 11.3 тэрбум төгрөг нь сангийн хөрөнгийн шинж чанартай худалдан авалтууд байна. Мөн шууд худалдан авалт 830 ш, харьцуулалтын аргаар 476 ш, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 336 ш, нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар 20ш, ерөнхий гэрээний аргаар 26 ш бүхий худалдан авалтын төлөвлөгөөг тус тус хянан баталгаажуулсан ба үүнээс ажил 222 ш, үйлчилгээ 524 ш, бараа 923 ш байна. 2025 оны эхний 11 сарын байдлаар нийтдээ 20 удаагийн 141.2 тэрбум төгрөгийн нэмэлт өөрчлөлт орсон байна.

Төрийн өмчид бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлж, өмчийн эзэмшилт, ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд:

2024 оны "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний биелэлтийг хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, хөрөнгийн хөдөлгөөн, бүртгэл, мэдээ тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тайлагналтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн байдал, Төрийн болон орон нутгийн өмчийн цахим мэдээллийн системд захиргааны статистикийн мэдээг оруулсан байдлын үнэлгээ, дүн, дүгнэлтийг нэгтгэж, төрийн өмчит 900 хуулийн этгээдийн гэрээг дүгнэж, гэрээний биелэлтийн **улсын дундаж үнэлгээ 82.0 хувьтай** дүгнэгдлээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үнэлгээ 5.1 хувиар буурсан шалтгаан нь газар, тээврийн хэрэгсэл, барилга, байгууламж хөрөнгүүд нь төрийн бусад төрөлжсөн цахим системд зөрчилтэй байгаатай холбоотой байв.

2025 оны жилийн эцсийн байдлаар төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг түрээслэх, ашиглуулах тухай өмнөх оны гэрээг сунгах, шинээр гэрээ байгуулах ажил төрийн өмчит 134 хуулийн этгээдийн түрээсийн 1028 гэрээг шинэчлэн байгуулах,

сунгах ажлыг хийж 4,3 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 400 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн дүнтэй байна.

Төрийн өмчит хуулийн этгээдийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдах ажлыг зохион байгуулж, нийт 39 байгууллагын 75 тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэж, 2025 оны жилийн эцсийн байдлаар 317 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд төрийн өмчит 1119 хуулийн этгээдийн 57,279.00 нэр төрлийн 2,04 их наядын төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн шилжилт, хөдөлгөөний зохицуулалт хийж, Засгийн газрын хуралдааны 5 тогтоол батлуулж, ТӨБЗГ-ын 563 тогтоол шийдвэрийг гаргуулж шийдвэрлэсэн байна.

Хөрөнгийн удирдлагад хяналт тавьж, бүрэн бүтэн байдлыг хангуулах, зардлыг бууруулах арга хэмжээний хүрээнд:

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өмчийн удирдлага, санхүүгийн үйл ажиллагаа, төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтын үр нөлөөг сайжруулж, зөрчил, доголдлыг арилгуулах ажлын хүрээнд 2025 онд төлөвлөгөөт 12 төсөвт 10, гүйцэтгэлийн 34, төлөвлөгөөт бус 2 хяналт, шалгалтыг нийт 58 хуулийн этгээдэд хэрэгжүүллээ.

2025 оны хяналт шалгалтад хамрагдсан 24 хуулийн этгээдийн хяналт шалгалтын тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж, 35.7 тэрбум төгрөгийн зөрчил дутагдал илрүүлсэн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 онд хэрэгжүүлсэн хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгасан байдалд 2025 оны 11 дугаар сарын 10-ны биелэлтийг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу үнэлж дүнг баталгаажуулсан.

/2025 оны дэлгэрэнгүй тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А-1/2470 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулж баталгаажуулсан./

2. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны жилийн эцсийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг хяналтад авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:

- Монгол Улсын 1 хуулийн 1 заалт 100.0 хувь;
- Улсын Их Хурлын 18 тогтоолын 36 заалт 97.8 хувь;
- Улсын Их Хурлын Байнгын хорооны 8 тогтоолын 17 заалт 95.4 хувь;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 5 зарлигийн 5 заалт 100.0 хувь;
- Засгийн газрын 56 тогтоолын 77 заалт 95.8 хувь;
- Засгийн газрын 32 хуралдааны тэмдэглэлийн 67 заалт 94.6 хувь;
- Засгийн газрын 2 албан даалгаврын 20 заалт 97.3 хувь;

– Ерөнхий сайдын 2 захирамжийн 2 заалт 100.0 хувь.

нийт 8 төрлийн 124 шийдвэрийн 225 заалтыг хяналтад авч, 2025 оны жилийн эцсийн байдлаар биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **дундаж үнэлгээ 96.04 хувь** байна.

Хяналтад авсан **8 төрлийн 124 шийдвэрийн 225 заалтын** биелэлтийн явц, үр дүнг харуулбал:

“Хэрэгжсэн” – 151 шийдвэр;

“Хэрэгжих шатанд” – 13 шийдвэр:

“Ахиц гарсан 50%” – 8 шийдвэр;

“Тодорхой үр дүнд хүрсэн 50%” – 2 шийдвэр;

“Удаашралтай/ эрчимжүүлэх шаардлагатай 50%” – 3 шийдвэр;

“Хугацаа болоогүй” – 44 шийдвэр;

“Хэрэгжих боломжгүй” – 17 шийдвэр:

“Хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй” – 3 шийдвэр;

“Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй” – 8 шийдвэр;

“Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй” – 3 шийдвэр;

“Хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй” – 3 шийдвэр;

Засгийн газрын шийдвэрээр зарим төрийн өмчит хуулийн этгээдийг нэгдлийн хэлбэрээр ажиллуулах болсноор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хэрэгжилт тайланг гаргах боломжгүй өөрөөр хэлбэл “Эрдэнэс монгол” ХХК, “Эрчист монгол” ХХК-д харьяалагдаж байгаа төрийн өмчит хуулийн этгээдүүдтэй холбоотой шийдвэрүүдийн хэрэгжилтийг чиг үүргийн хувьд хамааралгүй, хугацаа болоогүй төлөвөөр дүгнэж цахим системд тайлбарын хамт оруулж баталгаажуулсан болно.

Мөн төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлтэй холбоотой, 2022, 2023, 2024 оны төсвийн тухай хуультай холбоотой шийдвэрүүдийн заалтыг журмын дагуу тэмдэглэгээ хийж хасах саналыг хүргүүлсэн. Учир нь эдгээр шийдвэрүүдтэй агуулга ижил дараагийн шийдвэрүүд гарсан.

Цаг хугацааны хувьд тогтоосон хугацаатай, нэг удаагийн шинжтэй зарим тогтоол, шийдвэрүүдийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжсэн тэмдэглээ хийж, цахим сангийн хяналтаас хасуулах санал хүргүүлж байгаа болно.

/2025 оны дэлгэрэнгүй тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А-1/56 дугаар албан бичгээр Засагийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засагийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд хуулийн хугацаанд нь оруулж баталгаажуулсан болно/

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ЧАДАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

1. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Албан хаагчдыг мэргэшүүлэх, хөгжүүлэх, сургах чиглэлээр:



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2025 оны А/05 дугаар тушаалаар байгууллагын 2025 оны сургалтын төлөвлөгөөг байгууллагын дотоод болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулахаар нийт 34 сургалт төлөвлөж, 2025 оны жилийн эцсийн байдлаар 98 хувьтай хэрэгжсэн.



Удирдлагын академийн сургалтын төлөвлөгөө квотын дагуу зохион байгуулагдсан мэргэшүүлэх багц сургалтад нийт 7 албан хаагч хамрагдаж, амжилттай төгссөн. Үүнд:

- Эрхэлсэн түшмэлийн багц сургалтад – 1;
- Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад – 1;
- ТАХ-ийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад – 3;
- Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад – 2.

Ажлын байранд зохион байгуулсан компанийн засаглал, авлигын эсрэг, хууль, эрх зүй, төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл ашиглалтын нэгдсэн цахим систем, төрийн албан хаагчийн ёс зүйн зэрэг сургалтад нийт давхардсан тоогоор 430 албан хаагч хамрагдаж, төлөвлөгөөнд батлагдсан 27.0 сая төгрөгөөс 2.0 сая төгрөгийн төсөв зарцуулсан байна.

- Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт;
- Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Азийн Бүс ба Зам Санаачилгын түнш орнуудын төрийн өмчит аж ахуйн нэгжийн манлайллыг дэмжих хөтөлбөр"-ийн 14 хоногийн сургалтад – 9;
- Бүгд Найрамдах Энэтхэг Улсын "Техник, Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны хөтөлбөр"-ийн "Санхүүгийн удирдлага ба дотоод аудит" сургалтад – 2;
- Австрали улсын Мелбурн хотод Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллагаас зохион байгуулагдсан компанийн засаглалын сургалтад – 1;
- Шинэ Зеланд улсад Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ийн дарга С.Бямбацогтын ажиллах хөтөлбөрийн хүрээнд төрийн өмчит компаниудын сайн засаглалыг хөгжүүлэх чиглэлээрх сургалтад – 2 нийт 14 албан хаагч зохион байгуулагч талын зардлаар гадаад сургалтад хамрагдсан байна.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 52 дугаар "Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын 2 дугаар хавсралтаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын орон тооны дээд хязгаар 51-ээр батлагдсан. Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд 2025 оны төсөв 3.5 тэрбум төгрөгөөр батлагдсанаас, тодотголоор 2.8 тэрбум төгрөг батлагдаж, 688.0 сая төгрөгийн хэмнэлт гарсан. Үр ашиггүй гэж тодотголоор хэмнэгдсэн зардлуудыг дурдвал, гадаад болон дотоод томилолтын зардал, мэдээлэл сурталчилгааны зардал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зардал, ажил

олгогчоос олгох тэтгэмжийн зардал, тээвэр шатахууны зардал, хичээл үйлдвэрлэл, дадлага сургалтын зардлууд тус тус хасагдсан байна. Бүтэц, орон тооны хэмнэлтийн хүрээнд цалингийн зардлаас 100.0 сая төгрөг хасагдсан, энэ нь нийт 4 орон тоо хасагдсантай холбоотой юм.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны батлагдсан цалингийн төсөв 1.8 тэрбум төгрөг байсан ба нийт 50 албан хаагчид цалин, урамшуулал, тэтгэмж, хоол унааны нэмэгдэл зэрэгт 100 хувийн гүйцэтгэлтэй зарцуулагдсан. Тухайлбал,

- Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалинд өөрчлөлт орсонтой холбогдон, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин 10 хувиар 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдсэн;
- "Төрийн жинхэнэ албан хаагчдын 2025 оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх үнэлгээний багийн шийдвэрийн дагуу нийт албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг хагас жил, жилийн эцсээр 1 сарын үндсэн цалингийн 40 хувиар тооцон олгож, нийт 149.4 сая төгрөг зарцуулсан;
- Өндөр насны тэтгэвэрт гарсан албан хаагчид 36 сарын тэтгэмж 1 хүнд 42.0 сая, ар гэрийн гачигдал тохиолдсон 3 албан хаагчид нийт 1.5 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгож, нийт 43.5 сая төгрөгийн дэмжлэг;
- Эрүүл мэндийн шалтгааны улмаас удаан хугацаагаар чөлөө авсан 1 албан хаагчид 2 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний буцалтгүй тусламж;
- Ар гэрийн шалтгааны улмаас чөлөө хүссэн 3 албан хаагчид 10-20 хоногийн цалинтай чөлөө тус тус олгосон;
- Цагаан сар болон Ахмадын баярын өдрийг тохиолдуулан байгууллагын ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэн 33 ахмадад нийт 16.5 сая төгрөгийн гарын бэлэг болон бэлэн мөнгө олгож, хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн байна.

Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйл, УИХ-ын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 79 дугаар зарлигаар 1 албан хаагч Тэргүүн түшмэлийн тэргүүн зэргээр;

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2025 оны Б/04 дүгээр тушаалаар Төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэвийг 14 албан хаагчид ахиулан болон шинээр олгууллаа. Тухайлбал,

- Дэс түшмэлийн тэргүүн зэргээр 5;
- Дэс түшмэлийн дэд зэргээр 4;
- Дэс түшмэлийн гутгаар зэргээр 2;
- Дэс түшмэлийн дөтгөөр зэргээр 3 албан хаагч тус бүр нэмэгдэл авч эхэлсэн байна.

Төрийн дээд одон медаль, салбарын шагналаар байгууллагын албан хаагчдын шагнуулсан байдал:

- Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор – 1;
- Алтан гадас одонгоор – 1;

- Монгол Улсын Засгийн газрын Хүндэт Өргөмжлөл* – 1;
- Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр – 4;
- Бүртгэл, статистикийн тэргүүний ажилтан цол тэмдгээр – 1 нийт 8 албан хаагч тус тус шагнагдсан байна.

Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Ахмад настнууд болон нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт Улсын нэгдүгээр төв эмнэлэгт хамруулж, уг арга хэмжээнд 23.8 сая төгрөг зарцуулсан.

ДӨРӨВ. ХӨНДЛӨНГИЙН БОЛОН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮНЭЛГЭЭ

1. НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ (ИЛ ТОД БАЙДАЛ, ШИЛЭН ДАНСНЫ ҮНЭЛГЭЭ)

Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан ёсны цахим сайт болох <https://pcsp.gov.mn/>, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим систем <https://umch.gov.mn/>, шилэн дансны <https://shilendans.gov.mn/organization/8324?ry=2025&group=117> сайт, төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас <https://www.gov.mn/mn/organization/pcsp>-д байршуулсан мэдээлэлд үндэслэн Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-д заасан аргачлалаар гүйцэтгэв.

Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-д заасан 5 бүлгийн 71 шалгуур үзүүлэлтээр тайлагнаж мэдээлэхээс Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь 2025 оны жилийн эцсийн байдлаар өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дараах 5 бүлгийн 46 шалгуур үзүүлэлтээр тайлагнаж, 100 хувийн гүйцэтгэлтэйгээр холбогдох цахим хуудсанд байршуулж, мэдээлсэн байна.

- Нэг.Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 10 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт – 100.0 хувь;
- Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 6 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт – 100.0 хувь;
- Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 15 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт – 100.0 хувь;
- Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 2 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт – 100.0 хувь;
- Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал: 13 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт – 100.0 хувь буюу ерөнхий дундаж үнэлгээ 100.0 хувьтай байна.

Төсөв, санхүүгийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтээс 2 үзүүлэлт 2026 оны 1 дүгээр улиралд дүгнэлт тайлан гарахаар хүлээгдэж байгаа тул хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй төлөвөөр үнэлсэн.

Байгууллагын чиг үүрэгт хамааралгүй 10 шалгуур үзүүлэлтийг мөн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй төлөвөөр үнэлж, ерөнхий үнэлгээнд тооцоогүй.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар:

Шилэн дансны тухай хууль, төсвийн тухай хууль, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор байгууллагын шилэн дансанд байршуулсан мэдээллийг батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй нь харьцуулж үзэхэд 2025 онд үндсэн үйл ажиллагааны буюу урсгал зардалд 3,536,745.9 мянган төгрөг батлагдаж тайлант хугацаанд нэг удаа улсын төсвийн тодотгол хийгдэж, төсөв 688,000.0 мянган төгрөгөөр буурч 2,848,141.7 мянган төгрөг болж, 2025 оны жилийн эцсийн байдлаар 91.2 хувь буюу 2,598,619.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй, 8.7 хувь буюу 249,522.6 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

2025 онд жилийн эцсийн байдлаар төсвийн тодотгол нэг удаа хийгдэж, төсвийн гүйцэтгэлээр цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 995, 108.9 мянган төгрөгийн 26 удаагийн зарлагын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4,156,200.3 мянган төгрөгийн 22 удаагийн орлогын мөнгөн гүйлгээ тус тус хийгдсэн байв.

2025 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалтаар 1, харьцуулалтын аргаар 1, шууд худалдан авах 1 нийт 272,000.0 мянган төгрөгийн 3 бараа, ажил, үйлчилгээ зохион байгуулахаар төлөвлөгдсөнөөс тайлант оны жилийн эцсийн гүйцэтгэлээр шууд худалдан авалтын 19,800.0 мянган төгрөгийн 1 бараа, ажил, үйлчилгээг зохион байгуулсан байна.

Шилэн дансны тухай хууль, журамд заасны дагуу 2025 онд төсөв/гүйцэтгэлийн 16 төрлийн 62 мэдээлэл, хөрөнгө, оруулалт, тендер, худалдан авалтын 6 төрлийн 39 мэдээлэл, бусад 7 төрлийн 73 мэдээлэл нийт 29 төрлийн 174 мэдээллийг <https://shilendans.gov.mn/organization/8324?ry=2025&group=117> -нд оруулж, **4 мэдээллийн хугацаа хоцроож 97.7 хувьтай** байна.

2. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 4.13. Байгууллага нь салбарын болон болон орон нутгийн хэмжээнд бодлогын баримт бичгийн үр дүн, үр нөлөөг судлах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хэрэглэгчийн үнэлгээ болон судалгаа хийж болно гэснийг удирдлага болгон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргаар "Байгууллагын үйл ажиллагааны хэрэглэгчийн үнэлгээг зохион байгуулах ажлын удирдамж"-ийг батлуулан гүйцэтгэлээ.

Судалгааг хамтран ажилладаг яам, агентлаг, төрийн өмчит хуулийн этгээд, орон нутгийн өмчийн газрын албан хаагчдаас 2025 оны 12 дугаар сарын 08-наас 12 дугаар сарын 12-ны хооронд ажлын 5 хоногийн хугацаанд цахим хэлбэрээр https://docs.google.com/forms/d/1fxzU037yBZbVRhMqJ9Y3Jcg5S13LCtRAXsL_Dg8jTif4/edit удирдамжид заасан 3 зорилтын хүрээнд санал асуулгыг авч үр дүнг нэгтгэлээ.

Зорилт 1.Байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийн үнэлгээ:

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, түүний чанар, хүртээмжтэй байдал;

Зорилт 2. Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ:

- Цахим сайтад байршуулсан мэдээллийн хүртээмжтэй байдал;

Зорилт 3. Байгууллагын албан албан хаагчийн ёс зүйн үнэлгээ:

- Албан хаагчийн мэргэжлийн ур чадвар, харилцаа, хандлага, ёс зүй, шударга байдал.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны "Хэрэглэгчийн үнэлгээ -2025" судалгааг хамтран ажилладаг яам, агетлаг, төрийн өмчит хуулийн этгээдийн албан хаагчдаас батлагдсан удирдамжийн дагуу **Байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмж, байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдал, байгууллагын албан албан хаагчийн ёс зүй гэсэн 3 зорилтын хүрээнд 15 асуумжаар ажлын 5 хоногийн хугацаанд цахимаар зохион байгуулав.**

Судалгаанд оролцогчдын 40.6 хувь нь төрийн үйлчилгээ, 32.5 хувь нь төрийн өмчит хуулийн этгээд, 2.5 хувь нь төрийн захиргааны төв, 1.5 хувь нь бусад, 2 хувь нь төрийн тусгай байгууллагын нийт 199 албан хаагчид хамрагдсан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гарч байгаа бодлого, шийдвэр, зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд судалгаанд оролцогчдын 133 буюу 67.2 хувь нь сайн буюу сэтгэл хангалуун гэж хариулсан бол 56 буюу 28.3 хувь нь дунд, 6 буюу 3 хувь нь мэдэхгүй, 3 буюу 1.5 хувь нь муу **дундаж үнэлгээгээр 4.4 оноо буюу 87.1 хувь нь сэтгэл хангалуун байдаг гэсэн үр дүн** гарсан байна.

Судалгаанд оролцогчдын 114 буюу 61.3 хувь нь хүссэн үйлчилгээгээ бүрэн авсан, 18 буюу 9.7 хувь нь хүссэн үйлчилгээгээ хагас дутуу авсан, 30 буюу 16.1 хувь нь хүссэн үйлчилгээгээ бүрэн авч чадаагүй ч ямар нэг хариу, хэрэгтэй зөвлөгөө авсан, 17 буюу 9.1 хувь нь хүссэн үйлчилгээгээ бүрэн авч чадаагүй, 7 буюу 3.8 хувь нь хүссэн үйлчилгээгээ бүрэн авч чадаагүй бөгөөд үйлчлэхээс татгалздаг гэж хариулсан тул албан хаагчид харилцаа, хандлагад анхаарч ажиллах, асуудлыг шийдвэрлэхэд нь зөв чиглүүлж байх шаардлагатай гэж дүгнэв.

Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан ёсны цахим хуудас <https://pcsp.gov.mn/> - д байршуулсан мэдээ, мэдээллийн хүртээмжтэй, ойлгомжтой, ил тод, нээлттэй байдлыг 4 асуумжийн нийлбэрээр (9, 10, 11) үр дүнгийн үнэлгээг тооцож гаргахад **4.2 оноо буюу 83.9 хувиар дүгнэсэн** байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан ёсны цахим хуудас <https://pcsp.gov.mn/>-нээс судалгаанд оролцогчдын 166 буюу 87 хувь нь хүссэн мэдээллээ авч чаддаг, 25 буюу 13 хувь нь өөрийн хүссэн мэдээ, мэдээллээ олж авч чаддаггүй, авах гэсэн мэдээлэл дутмаг байсан гэж хариулсан бөгөөд 2025 онд судалгаанд оролцогчдын тоо 2.4 дахин өссөн дүнтэй, 2024 онд зохион байгуулсан судалгааны үр дүнтэй харьцуулахад 73 иргэн буюу 88 хувь нь хүссэн мэдээллээ авдаг 10 иргэн буюу 12 хувь нь үгүй буюу өөрийн хүссэн мэдээ, мэдээллээ олж авч

чаддаггүй, авах гэсэн мэдээлэл дутмаг гэж хариулснаас дүгнэхэд цахим хуудасны шинэчлэлд тодорхой ахиц гараагүй байна гэж тодорхойлохоор байна.

Байгууллагын албан хаагчийн ёс зүйн үнэлгээг албан хаагчийн мэргэжлийн ур чадвар, ажилдаа хариуцлагатай хандаж байгаа байдал, ажилтны цагийн менежмент, харилцааны соёл, хандлага, ёс зүй, шударга байдал гэсэн асуумжийн нийлбэрээр (12,13,14,15) тооцож, дүнг нэгтгэн гаргахад судалгаанд оролцогчид **4.4 оноо буюу 87.3 хувиар дүгнэсэн** байна.

"Хэрэглэгчийн үнэлгээний – 2025" судалгааны 3 зорилтын хамгийн бага үнэлгээтэйгээр **байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдал** дүгнэгдсэн байна.

"Хэрэглэгчийн үнэлгээ – 2025" судалгааны үр дүнг байгууллагын үйлчилгээний чанар хүртээмж (асуумж 2,3,4,5,6,7), мэдээ, мэдээллийн ил тод байдал (асуумж 8,9,10,11), албан хаагчдын ёс зүй (асуумж 12,13,14,15) гэсэн 3 зорилтын хүрээнд тодорхойлоход **4.3 оноо буюу 86.1 хувиар дүгнэгдсэн бөгөөд 2024 онтой (85.7) харьцуулахад 0.4 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна.**

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА **Б.ЦЭНГЭЛ**

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА **Н.ГАНБОЛД**

Тайланг боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН **Д.ЦЭРЭНЛХАМ**